ДАГАЛДАХ ХУУЛИУД

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

1. Хууль:

1.1. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай

1.2. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.3. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.4. Хууль хүчингүй болсонд тооцох тухай

1.5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

2. Улсын Их Хурлын тогтоол:

2.1. Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай

2.2. Засгийн газарт чиглэл өгөх тухай

2.3. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

ТАНИЛЦУУЛГА

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газар ирэх онд эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөөд байгаа билээ.

Хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох, төсөв хооронд үе шаттай, оновчтой зохицуулалт хийх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаа.

Ирэх 2025 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгээс Ирээдүйн өв санд хуваарилах хувь 2025 онд 40 байхаар хуулийн төсөлд тусгалаа.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвийн орлого нэмэгдэх, бүтээн байгуулалтын төслийг санхүүжүүлэх, төсвийн тэнцэл сайжрах, алдагдал буурах нөхцөл бүрдэнэ.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "2024 онд 20" гэсний дараа ", 2025 онд 40" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай" тогтоолоор Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор тодорхой бүсүүдийг тогтоож, тэдгээрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлон, эдийн засаг болон бизнесийн таатай орчныг бүрдүүлэхээр тусгасан.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.1-д "Татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах зарчим баримталж, бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих" гэж заасан.

Дээрх бодлогын баримт бичгүүдэд туссан бүсчилсэн хөгжлийн бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг зөвхөн улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх боломжгүй тул татварын бодлогоор хувийн хэвшлийг урамшуулан идэвхжүүлэх бодлого баримтлах нь зүйтэй байна.

Иймд Засгийн газраас тогтоосон бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдсан импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үйл ажиллагаанаас олох орлогод ногдуулах албан татварыг эхний 5 жилд 90 хувь хөнгөлж, төрөөс татварын дэмжлэг үзүүлэх, хуулийн давхардлыг арилгах зорилгоор Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн төслийг боловсруулаа.

Хуулийн төсөл батлагдсанаар хувийн хэвшил томоохон бүтээн байгуулалт хийх идэвх санаачилга нэмэгдэж, шинээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг урагшлуулах, цаашлаад бүс нутгийн эдийн засгийн онцлогт нийцүүлэн хөрөнгө оруулалтын урсгал нэмэгдэх чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр баталсан Аж ах ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг виртуал бүсийн татварын хөнгөлөлт нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын дэмжлэгтэй давхардаж, зөрчил үүсэж болзошгүй тул Төсвийн байнгын хорооноос энэ асуудлыг нэг мөр цэгцлэх асуудлыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэхийг чиглэл болгосон. Иймд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.18, 15.1.19 дэх заалтыг хүчингүй болгон 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсэгт заасан татварын дэмжлэгтэй нэгтгэн томьёолохоор хуулийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн, Монгол Улс Европын холбооны “Татварын зорилгоор хамтран ажилладаггүй бүс нутгийн жагсаалт”-аас гарахад Татварын суурийг бууруулах, ашиг шилжүүлэх явдлын эсрэг (“BEPS”) байгууллагын 13 дугаар дүрэмд заасан Улс

бүрээр үнэ шилжилтийн тайлантай холбоотой олон улсын стандартыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. Энэ хүрээнд улс бүрээр үнэ шилжилтийн гаргах үүрэгтэй үндэстэн дамнасан корпорацын орлогын босго олон улсын стандарт 750 сая еврог тухайн үеийн ханшаар хөрвүүлэн 1.7 их наяд төгрөг гэж хуульд тусгасан билээ. Гэвч ханшийн зөрүүний улмаас энэ дүн еврогоор илэрхийлэхэд олон улсын стандартаас зөрүүтэй болж байгааг өөрчлөн, хуульд еврогоор тусгах шаардлага, зөвлөмжийг ЭЗХАХБ-аас ирүүлж байгааг хуулийн төсөлд тусгалаа.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/22 дугаар зүйлийн 22.5.22 дахь заалт:

"22.5.22.албан татвар төлөгчийн 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 5 жил 90 хувиар."

2/22 дугаар зүйлийн 22.9.11 дэх заалт:

"22.9.11.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдийн хуульд заасан үйл ажиллагаа."

3/22 дугаар зүйлийн 22.14, 22.15 дахь хэсэг:

"22.14.Энэ хуулийн 22.5.22-т заасан төслийн жагсаалтыг Засгийн газар батална.

22.15.Энэ хуулийн 22.5.11, 22.5.20, 22.5.21, 22.5.22-т заасан хөнгөлөлтийг давхардуулан эдлэхгүй."

4/27 дугаар зүйлийн 27.11 дэх хэсэг:

"27.11.Энэ хуулийн 27.1.6-д заасан гадаад валюттай харьцах төгрөгийн ханшийг Монголбанкнаас зарласан тухайн татварын жилийн дунджаар тооцож дараагийн татварын жилийн 1 дүгээр сард багтаан татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага өөрийн цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлнэ."

2 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.15 дахь хэсгийн "22.5.16-д" гэснийг "22.5.16, 22.5.22-т" гэж, 27 дугаар зүйлийн 27.1.6 дахь заалтын "1.7 их наяд" гэснийг "750 сая евротой тэнцэх" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.18, 15.1.19 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг 2035 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл, 1 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, 2 дугаар зүйлийн 26.15 дахь хэсгийн өөрчлөлтийг 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Гаалийн тариф, гаалийн татварын
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 5.3-т бүсийн хөгжлийн бодлогод нийцсэн татварын бодлого хэрэгжүүлэхээр, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.1-д татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах зарчим баримталж, бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжихээр тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газраас бүс бүрийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувьд төрөлжсөн болон дэд тэргүүлэх чиглэлтэй байхаар төлөвлөн 2024-2028 онд бүсчилсэн хөгжлийн реформын цогц асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна. Уг реформын хүрээнд хийгдэх бүсчилсэн хөгжлийн бүтээн байгуулалтын ажлыг зөвхөн улсын төсвийн эх үүсвэрээр хийх боломжгүй тул хувийн хэвшлийг урамшуулан идэвхжүүлэх бодлого баримтлах нь зүйтэй байна.

Түүнчлэн "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Засгийн газраас 2030 он гэхэд боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэлхийн брэндийн түвшинд хөгжүүлэн, боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа ба өнгөрсөн жилүүдэд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг түлхүү дэмжиж ирсэн. Цаашид эдийн засгаа төрөлжүүлэх алхмуудыг хийж, бүх төрлийн боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэн импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих шаардлагатай байна.

Иймд хувийн хэвшлийг бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт хийхийг сэдэлжүүлэн, урамшуулах, түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх зорилгоор Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаа.

Хуулийн төсөлд Засгийн газрын шийдвэрээр НӨАТ төлөх хугацааг сунгасан бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцсэн, техник, эдийн засгийн үндэслэл бүхий томоохон төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын ажлын үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлж, боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн иж бүрдлийг импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлөхөөр тусгасан болно.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/38 дугаар зүйлийн 38.1.26 дахь заалт:

"38.1.26.энэ хуулийн 40.8-д заасны дагуу тогтоосон ажлын үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах барилгын материал, тоног төхөөрөмж."

2/38 дугаар зүйлийн 38.4, 38.5 дахь хэсэг:

"38.4.Боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн иж бүрдлийг импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлнө.

38.5.Энэ хуулийн 38.4-т заасны дагуу импортоор оруулсан барааанд тухайн онд ногдуулан төлсөн гаалийн албан татварыг дараагийн төсвийн жилийн эхний хагас жилд татвар төлөгчид буцаан олгоно."

2 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн гарчгийн "чөлөөлөгдөх" гэснийг "чөлөөлөх, хөнгөлөх" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.8 дахь хэсгийн "гаалийн болон" гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт, 3 дугаар зүйлийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс, 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт, 2 дугаар зүйлийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Засгийн газраас 2030 он гэхэд боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэлхийн брэндийн түвшинд хөгжүүлэн, боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа ба өнгөрсөн жилүүдэд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг түлхүү дэмжиж байсан. Цаашид эдийн засгаа төрөлжүүлэх алхмуудыг хийж, бүх төрлийн боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэн импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээг хангах шаардлагатай байна.

Иймд түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулах үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн иж бүрдлийг 2030 он хүртэл импортын барааны гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлөхөөр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

Дээрх хуулийн төсөлд заасан боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хөнгөлөлтөд хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай тоног төхөөрөмж хамаарах тул хуулийн давхардал үүсгэхгүй байх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулаа.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн шийдвэр, тайлан мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулах нь компанийн сайн засаглалын олон улсын суурь зарчим юм. Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалын хаалттай байдал нь хуулийн этгээд үр ашиггүй ажиллах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх, төрийн өмч үнэгүйдэх, төрд үүсэх зардлыг нэмэгдүүлэх шалтгаан болж байна.

Иймд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хувьцаа эзэмшигчийн эрхийг нийтийг төлөөлөн хэрэгжүүлж байгаагийн хувьд ил тод, хараат бус, хөндлөнгийн хяналттай байх, компанийн үйл ажиллагаа ил тод байх зарчмыг бусад хувийн хэвшлийн хуулийн этгээдээс нэмэгдүүлсэн байдлаар хуульчлан үүрэгжүүлэх шаардлага үүсэж байна.

Шилэн дансны тухай болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, түүний гүйцэтгэл, зарцуулалт, тендерийн баримт бичиг, сонгон шалгаруулалт зэрэг мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгахаар зохицуулсан боловч төрийн өмчит хуулийн этгээдийн онцлогийг харгалзан хүний нөөц, орон тоо, удирдлага хэн болох, тэдгээрийн авч байгаа цалин хөлс, урамшууллын талаарх мэдээлэл болон санхүүгийн ил тод байдал, хувьцааны удирдлага, гэрээ хэлцэл, компанийн өр, зээл, төлбөртэй холбоотой мэдээллийг ил тод байршуулах нь олон нийтийн болон хараат бус, хөндлөнгийн хяналтыг өргөжүүлж, сахилга хариуцлагыг сайжруулж, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Дээрх зорилтыг хангах хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд хуулийн этгээдийн дүрэм, засаглалын дотоод журам, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, аудитын болон санхүүгийн тайлан, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл, бусдаас авсан дэмжлэг, хандив, тусламж, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх удирдлагын нэр, цалин хөлс, урамшууллын дүн зэрэг мэдээллийг нийтэд нээлттэй мэдээлэх үүргийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хүлээлгэсэн зохицуулалтыг нэмэлтээр тусгалаа. Тус үүргийг биелүүлээгүй нь хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагад хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийг нэгтгэн боловсруулж, их өгөгдөл үүсгэх, үйл ажиллагааг нь сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэхээр их өгөгдлийн шинжилгээнд суурилсан шийдвэр гаргах зорилгоор төрөлжсөн мэдээллийн санг бий болгож, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан ажиллахаар тусгалаа.

Түүнчлэн, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд төрийн аудитаас гадна шаардлагатай тохиолдолд Засгийн газрын шийдвэрээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэх зохицуулалтыг нэмж тусгалаа.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/21[1] дүгээр зүйлийн 11, 12, 13, 14 дэх хэсэг:

"11.Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт, сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно.

12.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, 6.8, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээлэл болон дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд болон өөрчлөлт орсон тухай бүр өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ:

1/хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, менежментийн төлөвлөгөө;

2/хуулийн этгээдийн өмнө зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан хувьцааны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, биет болон биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл;

3/хуулийн этгээдийн сүүлийн таван жилийн хөндлөнгийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлан;

4/хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;

5/хуулийн этгээдийн байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл;

6/хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэх санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, гэрээ болон гүйцэтгэлийг дүгнэсэн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх тухай гаргасан шийдвэр;

7/хуулийн этгээдийн эрэг, эсхүл хуулийн этгээдтэй холбогдуулан гаргасан нэхэмжлэл, хэрэг маргаан, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн хуульч, өмгөөлөгч, хуулийн фирмийн талаарх мэдээлэл;

8/хуулийн этгээдийн дүрэм, хуулийн этгээдийн үйл ажиллагааны болон хуулийн этгээдийн засаглалын дотоод журам;

9/тухайн жил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын болон бусад үйл ажиллагааны мэдээлэл, тэдгээрийн хэрэгжилтийн байдал;

10/бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын талаарх мэдээлэл, нийлүүлэгч этгээд, гэрээний хугацаа, үнийн дүн, сонгон шалгаруулалтын аргачлал, явц;

11/Төрийн болон албаны нуцын тухай хууль болон Байгууллагын нуцын тухай хуульд заасан нууц болон хаалттай, хязгаарлалттай мэдээлэл агуулаагүй төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;

12/төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн;

13/байгууллагын нуцад хамааруулсан мэдээллийн жагсаалт;
14/тухайн санхүүгийн жилд төлсөн албан татвар, төлбөр, хураамж;
15/төсвөөс болон бусад эх үүсвэрээс авсан дэмжлэг, хандив, тусламж.

13.Энэ зүйлд заасан мэдээллийг нийтэд мэдээлэх, эрх бүхий байгууллагад тайлагнах үүргийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээнд тусгана.

14.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийг нэгтгэн боловсруулж их өгөгдөл үүсгэх, үйл ажиллагааг нь сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэхээр их өгөгдлийн шинжилгээнд суурилсан шийдвэр гаргах зорилгоор төрөлжсөн мэдээллийн сантай байна. Мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журмыг Засгийн газар тогтооно.

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"79 дүгээр зүйл. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эрх

Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэ хуулийн 14, 16, 17, 21 дүгээр зүйл, 21^1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ."

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай
Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн зорилтуудыг үндэслэн "Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаа.

Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 26 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн зорилт 2-т "Засгийн газрын гадаад үнэт цаас төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна" гэж заасан. Энэхүү зорилтын хүрээнд 2026 оны 04 дүгээр сард эргэн төлөх хуваарьтай "Номад" бондын төлбөр болох 578.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг төсөвт дарамт учруулахгүйгээр өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Түүнчлэн, дээрх стратегийн баримт бичгийн зорилт 4-т "Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийн дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна." гэж заасны дагуу Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, жишиг хүүг тогтоох, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор Засгийн газрын дотоод үнэт цаасыг арилжаалж эхлэхээр төлөвлөөд байна.

Иймд Засгийн газрын өрийн оновчтой багцын бүтцийг бий болгох, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бага зардлаар, боломжит эрсдэлийн түвшинд байлгах зорилгоор Засгийн газрын үнэт цаасыг олон улсын болон дотоодын зах зээлд арилжаална.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Дугаар ...

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Өрийн удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2025 онд гадаад, дотоод үнэт цаас гаргах асуудлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн шийдвэрлэх эрхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т олгосугай.

2.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Засгийн газарт чиглэл өгөх тухай
Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Эдийн засаг дахь төрийн оролцоо өндөр хэвээр, төр аж ахуйн шинжтэй үйл ажиллагааг хувийн хэвшилтэй зэрэгцэн төрийн өмчит компани, үйлдвэрийн газар байгуулах замаар эрхэлж байгаа нь үр ашиггүй ажиллах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө үнэгүйдэх, төрд үүсэх зардлыг нэмэгдүүлэх шалтгаан болж байна.

Иймд төрийн өмчит компаниудын засаглалыг олон улсын сайн жишигт нийцүүлэн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагыг хараат бус, мэргэжлийн экспертүүдээс бүрдүүлэх, ил тод байдал, сахилга батыг сайжруулж, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Дээрх шаардлагыг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор "Засгийн газарт чиглэл өгөх тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаа.

Тогтоолын төсөлд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, менежментийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий хуулийн этгээдтэй хамтран төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээний үндсэн дээр хуулийн этгээдийг өөрчлөн зохион байгуулах арга хэмжээ авах, төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд худалдах үндсэн чиглэлийн талаар холбогдох санал боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгахаар тусгалаа.

Түүнчлэн, Засгийн газраас хэрэгжүүлж буй ногоон хөгжлийн бодлогыг эрчимжүүлэх хүрээнд Төрийн банк болон төрийн өмчит бусад санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн ногоон хөгжлийг дэмжих тусгайлсан чиг үүргээр шинэчлэн зохион байгуулж, агаар, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй төсөл хөтөлбөр, хэрэглээг урамшуулан

дэмжсэн санхүүгийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмж, санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглүүлэхээр төсөлд тусгалаа.

Мөн нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд төрийн зарим байгууллагуудыг нийслэл хотоос нүүлгэн шилжүүлэх талаар Засгийн газарт өгөх чиглэлийг тусгав.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр | Дугаар ... | Төрийн ордон, Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗАРТ ЧИГЛЭЛ ӨГӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж, олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, менежментийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий хуулийн этгээдтэй хамтран төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах;

1.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг харгалзан бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, үр ашгийг сайжруулах, зардлыг бууруулах асуудлыг судалж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хуулийн этгээдийг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах арга хэмжээ авах;

1.3.Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд худалдах үндсэн чиглэлийн талаар холбогдох санал боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

1.4.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох;

1.5.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх;

1.6.Төрийн банк болон төрийн өмчит бусад санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн ногоон хөгжлийг дэмжих тусгайлсан чиг үүргээр шинэчлэн зохион байгуулж, агаар, орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний

хэмнэлттэй төсөл хөтөлбөр, хэрэглээг урамшуулан дэмжсэн санхүүгийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмж, санхүүжилтийг нэмэгдүүлэх.

2.Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

2.1.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик, тээврийн сургуулийг Хөшгийн хөндийд, Хөдөө, аж ахуйн их сургуулийн Агроэкологийн сургуулийг Дархан хотод нүүлгэн шилжүүлж, хичээлийн байр, оюутны болон багш, ажиллагсдын байр зэргийг цогц байдлаар төлөвлөн сургуулийн хотхон хэлбэрээр байгуулахад шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, багш, ажиллагсдын нийгмийн асуудал, холбогдох урсгал болон хөрөнгийн зардлыг шийдвэрлэх, нүүлгэн шилжүүлэх;

2.2.Нийслэл Улаанбаатар хотоос шилжүүлэн байршуулах боломжтой төрийн байгууллагуудыг орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжид нүүлгэх, нийслэл Улаанбаатар хотод чөлөөлөгдөх барилга, байгууламжийг худалдан борлуулах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай
Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан ба уг хуулиар Олон улсын ургамал хамгааллын конвенцоор хүлээсэн үүргийн дагуу хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажиллахаар зохицуулсан.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч"-ийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" хэсэгт "Ургамал хамгааллын газар"-ыг нэмэхээр "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулаа.

Тогтоолын төсөл батлагдсанаар газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах, байгаль, цаг уурын болон бусад болзошгүй эрсдэлээс хамгаалах, бүтээгдэхүүний чанарт эергээр нөлөөлж ургацын хэмжээг нэмэгдүүлэн улмаар хүн амын хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжийг бүрдүүлэх ба нөгөө талаас импортын болон эх орны төмс, хүнсний ногоонд пестицидийн үлдэгдэл хэмжээ, хүний эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлийн үнэлгээг үнэлэх судалгаа шинжилгээний ажлыг орчин үеийн шаардлага хангасан багаж төхөөрөмж, олон улсын аргачлалын дагуу үнэн зөв хийж, хэрэглэгчдийг шинжлэх ухааны үндэслэлтэй, нотолгоонд суурилсан мэдээллээр хангах ач холбогдолтой гэж үзэж байна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Дугаар ...

Төрийн ордон, Улаанбаатар хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 13 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсэгт “Ургамал хамгааллын газар” гэж нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

4. ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА

БАТЛАВ
САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт "Баялгийн сангийн төсөв нь нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна." гэж, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.58 дахь заалтад ""Үндэсний баялгийн сангийн төсөв" гэж Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу төрөлжсөн сан бүрд төвлөрүүлж, зарцуулах, хуримтлал үүсгэх зорилгоор тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг" гэж, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх" гэж тус тус заасан нь Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн Монгол Улсын Засгийн газрын ирэх дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлэх талаар тодорхой зорилтууд тусгагдсан.

Тодруулбал, "байгалийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, "Ирээдүйн өв сан"-д ирээдүй үедээ хуримтлал үүсгэж, зээлжих зэрэглэл өндөртэй Засгийн газруудын үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийнэ" гэж, "Үндэсний баялгийн сангаар дамжуулан иргэдийг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлж, орон сууцжуулалтыг эрчимжүүлнэ" гэж заасан.

Иймд Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг дээр дурдсан зорилтуудтай нийцүүлэн боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 2 бүлэгтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомжийн талаар;

Хоёрдугаар бүлэгт Үндэсний баялгийн санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, төрөлжсөн сангуудад хуримтлуулах, сангаас хөрөнгө оруулалт хийх хэмжээ болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2025 оны төсвийн жилд орлого төвлөрүүлж, хуримтлуулан Үндэсний баялгийн сангаар дамжуулан байгалийн баялгийг хуваарилах Үндсэн хуулийн суурь зарчим хангагдана.

Ирээдүйн өв санд хуримтлагдсан хөрөнгийг олон улсын зах зээлийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар үнэ цэнийг өсгөх, арвижуулах боломж бүрдэнэ.

Түүнчлэн Хуримтлалын сангаас хийх хөрөнгө оруулалтаар дамжуулан орон сууцжуулалтыг эрчимжүүлж, хуримтлалыг хуульд заасан нөхцөлөөр арвижуулна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр батлагдан, хүчин төгөлдөр хэрэгжиж эхлээд байна.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн Монгол Улсын Засгийн газрын ирэх дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлэх талаар тусгагдсан зорилтуудтай нийцүүлэн Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулаа.

Ирэх 2025 онд Үндэсний баялгийн санд хуульд заасан эх үүсвэрээс нийт 2,356,827.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцож байна. Түүнчлэн Ирээдүйн өв санд хуримтлагдсан хөрөнгийг олон улсын зах зээлд хөрөнгө оруулах замаар арвижуулах бөгөөд Хуримтлалын сангаас хийх хөрөнгө оруулалтаар дамжуулан орон сууцжуулалтыг эрчимжүүлж, хуримтлалыг хуульд заасан нөхцөлөөр арвижуулна.

---o0o---

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр батлагдан, хүчин төгөлдөр хэрэгжиж эхлээд байна.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн Монгол Улсын Засгийн газрын ирэх дөрвөн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлэх талаар тодорхой зорилтууд тусгагдсан.

Тодруулбал, "байгалийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, "Ирээдүйн өв сан"-д ирээдүй үедээ хуримтлал үүсгэж, зээлжих зэрэглэл өндөртэй Засгийн газруудын үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийнэ" гэж, "Үндэсний баялгийн сангаар дамжуулан иргэдийг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлж, орон сууцжуулалтыг эрчимжүүлнэ" гэж заасан.

Иймд Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг дээр дурдсан зорилтуудтай нийцүүлэн боловсруулаа.

Ирэх 2025 онд Ирээдүйн өв санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 1,849,712.5 сая төгрөг төвлөрүүлэх ба санд хуримтлагдсан хөрөнгийг олон улсын зах зээлд хөрөнгө оруулах замаар арвижуулна.

Хуримтлалын санд хуульд заасан эх үүсвэр буюу уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгаас 507,114.8 сая төгрөг, хүүгийн орлогоор 55,013.4 сая төгрөг тус тус төвлөрүүлэхээр тооцож байна. Түүнчлэн Хуримтлалын сангаас хийх хөрөнгө оруулалтаар дамжуулан орон сууцжуулалтыг эрчимжүүлж, хуримтлалыг хуульд заасан нөхцөлөөр арвижуулна.

Хуулийн төслийн зүйл тус бүрээр:

Хуулийн төсөл 2 бүлэгтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомжийн талаар;

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ –*Хуулийн зорилтыг тусгана.*

***2 ДУГААР ЗҮЙЛ** – Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомжийн талаар тусгана.*

Хоёрдугаар бүлэгт Үндэсний баялгийн санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, төрөлжсөн сангуудад хуримтлуулах хэмжээ, хөрөнгө оруулалт хийх хэмжээ болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

***3 ДУГААР ЗҮЙЛ** – Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд төвлөрүүлэх орлогын хэмжээг тусгасан.*

***4 ДҮГЭЭР ЗҮЙЛ** – Ирээдүйн өв сангийн хуримтлалын үлдэгдэл болон 2025 онд нэмж хуримтлуулах хэмжээг тусгасан.*

***5 ДУГААР ЗҮЙЛ** – Хуримтлалын санд 2025 онд нэмж хуримтлуулах хэмжээг тусгасан.*

***6 ДУГААР ЗҮЙЛ** – Хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагын хүрээнд хөрөнгө оруулалт хийх хэмжээг тусгасан.*

***7 ДУГААР ЗҮЙЛ** – Хуулийн дагаж мөрдөх хугацааг тусгасан.*

---o0o---

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хот

,

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгох, хуримтлал үүсгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж

2.1. Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж нь Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО

3 дугаар зүйл.Үндэсний баялгийн санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	**Монгол Улсын Ерөнхий сайд**	**507,114.8**
	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	507,114.8
	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.2-т заасан уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцааны ногдол ашиг	507,114.8
	Үүнээс: Хуримтлалын санд	507,114.8
2	**Сангийн сайд**	**1,849,712.5**
	Татварын ерөнхий газар	1,849,712.5
	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1.а-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгээс 40 хувь	1,849,712.5

	Үүнээс: Ирээдүйн өв санд	1,849,712.5
	Нийт орлого	**2,356,827.3**

4 дугаар зүйл. 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 3,687,339.3 сая төгрөг байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу Ирээдүйн өв санд 2025 оны төсвийн жилд 1,849,712.5 сая төгрөг хуримтлуулна.

5 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасны дагуу Хуримтлалын санд 2025 оны төсвийн жилд 562,125.2 сая төгрөг хуримтлуулна.

6 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562,125.2 сая төгрөгөөр баталсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА

БАТЛАВ
САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

БАТЛАВ
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.32 дахь заалтад ""Нийгмийн даатгалын сангийн төсөв" гэж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн дагуу бүрдүүлж, зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас батлагдсан төсвийг" гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх" гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.9 дэх заалтад "Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг жил бүрийн намрын ээлжит чуулганаар хэлэлцэн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах" гэж тус тус заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2025 төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тогтооход баримталдаг итгэлцүүрийг жил бүр шинэчлэхээр заасан. Итгэлцүүрийг жил бүр улсын дундаж цалин хөлс, инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлснээр өөрийн төлсөн шимтгэлийн өнөөгийн үнэ цэнд нийцэхүйц өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах боломж бүрдэх юм.

Иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж өндөр насны тэтгэврийг 2023 оны 7 дугаар сараас 10 хувь, 2024 оны 4 дүгээр сараас 100.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлээд байна. Цаашид тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэврийг жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх шаардлагатай.

Тэтгэврийн хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттайгаар шилжих зорилгоор 2024 оноос тэтгэврийн нөөц санг бүрдүүлж эхлээд байна. Уг арга хэмжээг 2025 онд үргэлжлүүлэн ажил олгогч, даатгуулагчаас төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн тус бүр 1 хувь буюу нийт 2 хувь, сайн дурын даатгуулагчийн төлөх шимтгэлийн 2 хувийг тэтгэврийн нөөц санд хуримтлуулахад шаардагдах эх үүсвэрийг нийгмийн даатгалын сангийн төсөвт тусгах шаардлагатай.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 2 бүлэг, 6 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт Нийгмийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах төсвийн эрх хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн эргэн төлөх төлбөрийн тухай болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2025 оны төсвийн жилд нийгмийн даатгалын сангийн эх үүсвэр бий болгож хуримтлуулах, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжид зориулан хөрөнгө зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй

холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл байхгүй болно.

---o0o---

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл нь 2 бүлэг, 6 зүйлтэй бөгөөд нэгдүгээр бүлэгт Нийгмийн даатгалын сангийн хуулийн зорилтыг тусгасан бол хоёрдугаар бүлэгт Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төвлөрүүлэх орлогын хэмжээ, зарцуулах зарлагын хэмжээ, эргэн төлөх төлбөрийн хэмжээ тус тус тусгагдсан.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн нийт шимтгэлийн орлогыг 5,491.3 тэрбум төгрөг, нийт зарлагыг 5,882.8 тэрбум төгрөгөөр тооцсон. Улсын төсвөөс тэтгэврийн даатгалын сангийн 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэр, цэргийн албан хаагчдын тэтгэвэр, Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуульд заасан нэмэгдэл болон тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд нийт 1,452.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тооцлоо.

Нийгмийн даатгалын сангуудаас тэтгэмжийн даатгалын сан, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, ажилгүйдлийн даатгалын сангийн тэнцэл тус тус ашигтай гарч, мөнгөн хөрөнгө нь хуримтлагдахаар байна.

---o0o---

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл нь 2 бүлэг, 6 зүйлтэй бөгөөд нэгдүгээр бүлэгт Нийгмийн даатгалын сангийн хуулийн зорилтыг тусгасан бол хоёрдугаар бүлэгт Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төвлөрүүлэх орлогын хэмжээ, зарцуулах зарлагын хэмжээ, эргэн төлөх төлбөрийн хэмжээ тус тус тусгагдсан.

Нийгмийн даатгалын сан

Монгол Улсын Засгийн газар бодлогын хүрээнд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж иргэдийн бодит орлогыг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Иргэдийн орлогыг хамгаалах чиглэлээр 2023 онд тэтгэврийг итгэлцүүр ашиглан нэмэгдүүлж тэтгэврийн зөрүү бууруулах, инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, 2024 оны 4 дүгээр сараас 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх зэрэг шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлж тэтгэвэр авагчдын бодит орлогыг нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд өндөр насны тэтгэврийн дундаж хэмжээ 826.2 мянган төгрөгт хүрээд байна.

